

**МОНГОЛ УЛСЫН 2023 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХАМТ
ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛЬ, МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН
ТӨСЛИЙН АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ЯВУУЛСАН ТАЛААРХ
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2022 оны 11 дүгээр
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн **101** хууль, **6** Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын чуулганы 2022 оны 10 дугаар сарын 13, 14-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороо болон бусад Байнгын хороодод шилжүүлсэн билээ.

Төсвийн байнгын хороо 2022 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн хуралдаанаараа дээрх хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж, дараах санал, дүгнэлтийг гарган Та бүхэнд танилцуулж байна.

Улсын Их Хурлын Байнгын хороод эрхлэх асуудлынхаа хүрээнд хамаарах хуулийн төслийг хэлэлцэн санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллын хамт Төсвийн байнгын хороонд ирүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын даргын 2022 оны 151 дүгээр захирамжаар Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан бөгөөд тус ажлын хэсгээс хууль, тогтоолын төслүүдийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг тус бүрээр нь санал хураалгаж, шийдвэрлэсэн болно.

Мөн Төсвийн байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсгийг үндэслэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр нь хэлэлцэн, төслийн тухайн зүйлтэй холбогдуулан гишүүн, бусад Байнгын хороо, ажлын хэсгээс гаргасан саналын томъёолол тус бүрээр санал хураалгасан.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгээс гарсан саналуудыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно. Үүнд:

1.Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн “Ирээдүйн өв санд хуваарилах хувь 2023 онд 0, 2024 онд 25, 2025 онд 45, 2026 оноос 65 байна” гэснийг “ирээдүйн өв санд хуваарилах хувь 2023 онд 0, 2024 оноос 65 байна” гэж өөрчлөх саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

2.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч хайгуулын ажлын явцад туршилтын журмаар олборлосон ашигт малтмалын төрөл, тоо, хэмжээг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлж зөвшөөрөл авсны үндсэн дээр худалдан борлуулж болох бөгөөд бүртгүүлсэн мэдээллийг татварын байгууллагад тухай бүр хүргүүлж ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй нэгэн адил төлж тайлагнана гэсэн саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

3.Гүйцэтгэх засаглалын хяналтын тухай хуулийн төслийн нэрийг “Засгийн газар дахь хяналтын тухай” гэж өөрчлөх, мөн төсөлд Улсын төсвийн санхүүжилттэй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээнд гүйцэтгэлийн хяналт шалгалт хийсэн бол төсвийн хяналтын сонсгол явуулна гэсэн саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

4.“Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь заалтын 1 дэх дэд заалтыг “улсын төсвөөс санхүүжүүлж хэрэгжүүлэхээр төсвийн тухай хуульд тусгаж батлагдсан төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн нэмэгдлийг Төрийн аудитын байгууллагын дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн төсвийн хуульд тусган шийдвэрлэх” гэж өөрчлөх; мөн төслийн 2 дахь заалтад Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн бараа, ажил, үйлчилгээний худалдан авалт, хөрөнгө оруулалт, татвар төлөлт, өр төлбөр, хүний нөөцийн мэдээллийг тухайн хуулийн этгээдийн цахим хуудаст ил тод нээлттэй байршуулах, Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн борлуулалт, экспортын гэрээг татварын нэгдсэн системд бүртгүүлэх, бүртгүүлээгүй тохиолдолд бүтээгдэхүүнийг экспортод гаргахгүй байх, борлуулалт болон худалдан авах нууц гэрээг Улсын Их Хуралд танилцуулах, Эрүүл мэндийн даатгалын санд үүссэн өр төлбөрийг 2023 оны төсвийн жилд өр төлбөр үүсгэхгүйгээр барагдуулах арга хэмжээ авах гэж нэмэх саналуудыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.


Байнгын хорооны хуралдаанаар хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед гарсан зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг олонхын дэмжлэг авсан, аваагүйгээр нь бүлэглэн Та бүхэнд тараасан.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн, шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Г.ТЭМҮҮЛЭН